

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/08/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/244

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар авлага данс өмнөх оноос 461,565.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 89,968.4 мянган төгрөгөөр тасалсан, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, Эмийн эргэлтийн сан санхүүгийн тайлан ирүүлээгүй зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ИТХ-ын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг үндэслэн Баян-Өнжүүл сумын түүхт 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт

G/Архив/Албан бичиг 2024/ А4

219920166

дэвшүүлсэн 8 зорилт 144 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 84,8%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар сумын онцгой комисст вагончик, халаалтын шугамын өргөтгөлийн ажлыг 315,400.0 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сургуулийн дотуур байрны дээврийн засвар, Соёлын төвийн хашаа, эко жорлон, ахуйн үйлчилгээ, халуун ус, үсчний газрын тохижилт, наадмын талбай, цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилтыг 146,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>838,815.9</b>	<b>1,416,869.5</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	306,209.7	344,346.8
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	422,854.4	884,419.7
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	109,751.8	188,103.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,801,792.0</b>	<b>1,837,590.9</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,801,792.0	1,837,590.9
39200	Биет хөрөнгө		1,714,805.2	1,751,127.4
39300	Биет бус хөрөнгө	13	86,986.8	86,463.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>2,640,607.8</b>	<b>3,254,460.4</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		78,841.5	111,676.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	78,841.5	111,676.6
41300	Өглөг	17а, 17б	78,841.5	111,676.6
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2,561,766.3</b>	<b>3,142,783.8</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		2,561,766.3	3,142,783.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		855,319.2	855,319.2
51200	Хуримтлагдсан үр дүн		1,294,554.9	1,875,588.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		411,892.2	411,876.3
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>2,640,607.8</b>	<b>3,254,460.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>2,599,156.0</b>	<b>1,848,574.2</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО		335,277.9	327,844.1
110	Орлогын албан татвар		148,287.2	178,072.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		157,015.6	188,072.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-8,728.4	-10,000.0
113	Хөрөнгийн албан татвар		45,018.9	62,104.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		141,971.9	87,666.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	256,483.3	282,989.3
120	Нийтлэг татварын бус орлого		256,483.3	240,894.3
122	Тусламжийн орлого		0.0	42,095.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,007,394.7	1,237,740.8
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>2,629,397.4</b>	<b>1,346,398.2</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,195,461.8	1,083,135.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		839,326.8	1,079,391.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		279,107.5	378,279.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		33,338.9	47,575.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		244,688.4	47,260.1
2104	Хангамж, бараа материалын зардал		36,086.9	40,157.2
2105	Нормативт зардал		33,634.0	22,669.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,467.4	2,661.2
2107	Томиллолт, зочны зардал		3,607.0	5,547.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,835.0	1,887.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		196,561.8	533,352.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,356,134.9	3,744.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		433,935.7	263,262.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>-30,241.5</b>	<b>502,175.9</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>3,320,057.2</b>	<b>-78,841.5</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>-3,350,298.7</b>	<b>581,017.5</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,916,751.0	5,916,751.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,686.0	-4,686.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,912,065.0	5,912,065.0
9	Тайлант үеийн үр дүн	-3,350,298.7	-3,350,298.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>2,561,766.3</b>	<b>2,561,766.3</b>
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>2,561,766.3</b>	<b>2,561,766.3</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,561,766.3	2,561,766.3
19	Тайлант үеийн үр дүн	581,017.5	581,017.5
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	<b>3,142,783.8</b>	<b>3,142,783.8</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	<b>2,455,304.0</b>	<b>1,696,361.2</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<b>335,277.9</b>	<b>327,844.1</b>
110	Орлогын албан татвар	148,287.2	178,072.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	157,015.6	188,072.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-8,728.4	-10,000.0
113	Хөрөнгийн албан татвар	45,018.9	62,104.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	141,971.9	87,666.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,062.6	6,070.7
1181	Газрын төлбөр	5,599.5	8,091.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	105,309.7	73,504.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>112,631.3</b>	<b>117,919.1</b>
120	Нийтлэг татварын бус орлого	112,631.3	75,824.1
122	Тусламжийн орлого	0.0	42,095.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>2,007,394.7</b>	<b>1,250,598.0</b>
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>2,051,685.3</b>	<b>1,102,877.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>2,051,685.3</b>	<b>1,102,877.0</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>675,549.9</b>	<b>1,099,132.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,577.6	378,279.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,799.0	48,177.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,183.4	47,286.9
2104	Хангамж, бараа материалын зардал	32,327.0	37,770.8
2105	Нормативт зардал	29,602.5	27,214.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,850.0	4,407.2
2107	Томилолт, зочны зардал	3,307.0	5,547.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,199.1	2,944.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,704.3	547,503.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,376,135.4	3,744.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<b>403,618.7</b>	<b>593,484.2</b>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	<b>878,127.3</b>	<b>485,347.1</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>878,127.3</b>	<b>485,347.1</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	878,127.3	485,347.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<b>-878,127.3</b>	<b>-485,347.1</b>
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	<b>-100.0</b>	<b>-70,000.0</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	<b>100.0</b>	<b>70,000.0</b>
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<b>-474,608.6</b>	<b>38,137.1</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	780,818.3	306,209.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	306,209.7	344,346.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,690,565.2</b>	<b>1,405,033.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>916,513.6</b>	<b>854,686.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>914,513.6</b>	<b>852,686.3</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,992.1	355,994.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,874.1	45,529.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	376,533.3	363,798.9
2104	Хангамж, бараа материалын зардал	34,775.1	34,774.6
2105	Нормативт зардал	600.0	473.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,557.2	10,057.2
2107	Томиллолт, зочны зардал	5,806.6	5,547.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,975.2	2,926.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,400.0	33,584.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000.0</b>	<b>2,000.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.0	2,000.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>654,051.6</b>	<b>480,347.1</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>120,000.0</b>	<b>70,000.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,690,565.2</b>	<b>1,473,240.2</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	407,342.4	397,145.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,011,513.6	1,006,162.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	230,014.2	27,837.4
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	41,695.0	42,095.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	82,628.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	150,835.2
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>52</b>	<b>52</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>14,940.6</b>	<b>236,379.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	14,940.6	236,379.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,107.4</b>	<b>217,690.6</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	22,284.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,648.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,032.8	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	302.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,772.6	192,757.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,833.2	18,689.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,833.2	18,689.1
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>14,940.6</b>	<b>236,379.7</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,940.6	236,379.7
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-0.91</b>	<b>0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.91	0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга “Хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шадар туслагч нь байхад оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ИТХ-ын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг үндэслэн Баян-Өнжүүл сумын түүхт 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сум тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар сумын онцгой комисст 5:3-ийн харьцаатай 24,400.0 мянган төгрөгийн өртөгтэй Вагончик “Эрчим-Өгий” ХХК, 291,000.0 мянган төгрөгөөр халаалтын шугамын өргөтгөлийн ажлыг Эко Энержи Ресурс ХХК, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дотуур байрны дээврийн засвар болон Эко жорлон 18,000.0 мянган төгрөгөөр Эко байгууламж од ХХК, Соёлын төвийн хашаа, эко жорлон 20,000.0 мянган төгрөгөөр, ахуйн үйлчилгээ, халуун ус, үсчний газрын тохижилт 20,000.0 мянган төгрөгөөр, наадмын талбай, цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилтын ажлыг 88,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант онд иргэн О.Алтанбаяр Баян-Өнжүүл сумын түүхт 50 жилийн ойгоор улсын алдарт уяач Д.Ханддоржийн Хонгор халзан морины хөшөөг өөрийн хөрөнгөөр хийж хандивласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 8 зорилт 144 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 84,8%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн "Дотоод хяналт зохион байгуулах ажлын хэсэг" А/02 тоот тушаал гаргаж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний баг тайлант онд дотоод хяналт шалгалт хийх 13 ажлын төлөвлөгөө боловсруулан Засаг даргын тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 613,852.5 мянган төгрөгөөр буюу 23,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	306,209.7	344,346.8	38,137.1
Авлага	422,854.4	884,419.7	461,565.3
Бараа материал	109,751.8	188,103.0	78,351.2
Үндсэн хөрөнгө	1,801,792.0	1,837,590.9	35,798.92
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,640,607.8</b>	<b>3,254,460.4</b>	<b>613,852.5</b>
Өр төлбөр	78,841.5	111,676.6	32,835.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,561,766.3	3,142,783.8	581,017.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,640,607.8</b>	<b>3,254,460.4</b>	<b>613,852.5</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 38,137.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 344,346.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тайлант онд орон нутгийн орлого 177,977.2 мянган төгрөгийн орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 140,383.6 мянган төгрөгийн хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сан 10,450.5 мянган төгрөг нь зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн мөнгө, Засаг даргын Тамгын газрын арилжааны банк дахь үлдэгдэл 1.0 мянган төгрөг, 9,516.9 мянган төгрөг нь байгаль хамгаалах сангийн үлдэгдэл, 6,017.5 мянган төгрөгийн эм эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 884,419.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 461,565.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сан 254,875.0 мянган төгрөгөөр гүйцэтгэх баяр наадмын цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, ЭМТ-ын хашаа, цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижуулалт, цаг уурын байрны их засварын ажил, гүн өрмийн худаг гаргах ажлуудыг дуусган хүлээлгэж өгөөгүйгээс үүссэн авлага, Хоршоо хөгжүүлэх сан 58,282.1 мянган төгрөгөөр, Засаг даргын Тамгын газар төрийн албан хаагчдын орон сууц, хийгдээгүй болон дуусган хүлээлгэж өгөөгүй ажлын авлага 147,921.5 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн сан 436.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 188,103.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,351.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 77,265.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 1,086.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,837,590.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,798.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эмийн эргэлтийн сан 3,722.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авснаас, Засаг даргын Тамгын газар 171,845.6 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 15,900.0 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 111,676.6 мянган төгрөг болж 32,835.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Засаг даргын Тамгын газрын 2022 онд Эко Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэсэн сумын гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох зардлын санхүүжилтийн үлдэгдэл өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 3,142,783.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 581,017.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 344,346.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 38,137.1 мянган төгрөгөөр буюу 12,5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	306,209.7	344,346.8	38,137.1
Төгрөг	306,209.7	344,346.8	38,137.1
Төрийн сангийн харилцах	295,715.6	338,328.2	42,612.6
Арилжааны банк дахь харилцах	10,494.0	6,018.6	(4,475.5)
<b>Дүн</b>	<b>306,209.7</b>	<b>344,346.8</b>	<b>38,137.1</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 344,346.8 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 338,328.2 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 6,018.6 мянган төгрөг байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 338,328.2 мянган төгрөгийн 52,6 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 177,977.2 мянган төгрөг, 41,5 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 140,383.6 мянган төгрөг, 3,1 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 10,450.5 мянган төгрөг, байгаль хамгаалах сан 2,8 хувь буюу 9,516.9 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна. Арилжааны банканд ЗДТГ-ын 1.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 6,017.6 мянган төгрөг байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 38,137.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оноос Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 110,369.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 25,593.2 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 42,163.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу ЗДТГ 1.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 4,476.4 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмээгдэл олгох тухай” захирамж, Баян-Өнжүүл сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот “Бүтэц, орон тоог батлах тухай” тушаалаар төрийн албаны улс төрийн 2 албан хаагчийн орон нутгийн нэмээгдэлд 2,726.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичив.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 884,419.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 461,565.3 мянган төгрөгөөр буюу 47,8 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	14,472.0	28,226.4	13,754.4
Байгууллагаас авах авлага	173,400.0	576,196.5	402,796.5
Хувь хүмүүсээс авах авлага	234,982.4	279,996.9	45,014.5
<b>Дүн</b>	<b>422,854.4</b>	<b>884,419.7</b>	<b>461,565.3</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 302,994.5 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 34,2 хувийг, байгууллагаас авах орон нутгийн хөгжлийн сангаар хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын дутуу ажлын авлага 428,275.0 мянган төгрөг буюу 48,4 хувийг, Засаг даргын Тамгын газрын авлага 147,921.5 мянган төгрөг буюу 16,7 хувийг, Эмийн эргэлийн сангийн авлага 5,228.8 мянган төгрөг буюу 0,7 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 884,419.7 мянган төгрөгийн 34,9 хувийг хувь хүмүүсээс авах зээл, зээлийн хүүгийн авлага, 65,1 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 12 иргэний 128,044.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын зөрчилд зөвлөмж өгөв.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 188,103.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,351.2 мянган төгрөгөөр буюу 71,4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>10,658.6</b>	<b>11,680.8</b>	<b>1,022.2</b>
Эм боох материал	10,658.6	11,680.8	1,022.2
<b>Хангамжийн материал</b>	<b>90,243.2</b>	<b>167,572.2</b>	<b>77,329.0</b>
Бичиг хэргийн материал	2,887.4	3,415.4	528.0
Аж ахуйн материал	41,125.0	90,765.9	49,641.0

Бусад хангамжийн материал	46,230.9	73,390.9	27,160.0
<b>Мал амьтад</b>	<b>8,850.0</b>	<b>8,850.0</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>109,751.8</b>	<b>188,103.0</b>	<b>78,351.2</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга

Бараа материал дансны үлдэгдэл 188,103.0 мянган төгрөгийн 92,7 хувь буюу 174,407.4 мянган төгрөгийг Засаг даргын тамгын газар, 1,1 хувь 1,950,8 мянган төгрөг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эмийн эргэлтийн сангийн 11,744.8 мянган төгрөг буюу 6,2 хувийг бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 137,233.5 мянган төгрөгөөр, хандиваар авсан 18,181.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 77,064.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

**Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.**

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,837,590.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,798.9 мянган төгрөгөөр буюу 1,98 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,714,805.2</b>	<b>1,751,127.3</b>	<b>36,322.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,240,841.2	1,194,092.1	-46,749.1
Авто-тээврийн хэрэгсэл	155,060.4	170,300.7	15,240.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	72,483.5	73,068.6	585.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,820.2	106,528.4	100,708.2
Бусад үндсэн хөрөнгө	240,599.8	207,137.5	-33,462.3
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>86,986.8</b>	<b>86,463.5</b>	<b>-523.3</b>
Программ хангамж	870.8	347.5	-523.3
Бусад биет бус хөрөнгө	86,116.0	86,116.0	0.0
<b>Дүн</b>	<b>1,801,792.0</b>	<b>1,837,590.9</b>	<b>35,798.9</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 98,9 хувь буюу 1,817,968.7 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,9 хувь буюу 1,724.5 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сан, 0,2 хувь буюу 3,722.2 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 52,885.1 мянган төгрөг болж, худалдан авсан 52,188.0 мянган төгрөгийн хөрөнгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан 104,824.4 мянган төгрөг, шилжүүлэн авсан 53,732.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.**

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 111,676.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 32,835.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	78,841.5	111,676.6	32,835.1
<b>Дүн</b>	<b>78,841.5</b>	<b>111,676.6</b>	<b>32,835.1</b>

Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл Засаг даргын Тамгын газрын 2022 онд Эко Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэсэн сумын гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох зардлын санхүүжилтийн үлдэгдэл өглөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт: Аудитаар алдаа, зөрчил байхгүй байна.*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,142,783.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 581,017.5 мянган төгрөгөөр буюу 22,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	855,319.2	855,319.2	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,294,554.9	1,875,588.2	581,033.37
Өмнөх үеийн үр дүн	4,644,853.5	1,294,570.8	(3,350,282.76)
Тайлант үеийн үр дүн	(3,350,298.7)	581,017.5	3,931,316.13
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	411,892.2	411,876.3	(15.91)
<b>Дүн</b>	<b>2,561,766.3</b>	<b>3,142,783.8</b>	<b>581,017.5</b>

*Эх сурвалж: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,142,783.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 581,017.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант үеийн үр дүн 581,017.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,122,784.3 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 339,803.5 мянган төгрөг, 2023 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,462,587.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5 дугаар тогтоолд зааснаар Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд 339,803.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 683,001.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 329,768.4 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 30,014.2 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 30,000.0 мянган төгрөгөөр, сумын орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 80,000.0 мянган төгрөгөөр нийт 1,462,587.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолд зааснаар Баян-Өнжүүл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 386,607.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 346,481.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 89,6 хувиар биелүүлж, 12 нэр төрлийн орлого 29,6 хувиар тасарсан байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх үйл ажиллагааны орлого 14,241.2 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 19,775.3 мянган төгрөгөөр, суутган-2 2,000.0 мянган төгрөгөөр, үл хөдөх хөрөнгийн албан татвар 1,106.6 мянган төгрөгөөр, бууны албан татвар 400.0 мянган төгрөгөөр, тэмдэгтийн хураамжийн орлого 23,707.3 мянган төгрөгөөр, ан агнуурын орлого 1,495.2 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 222.0 мянган төгрөгөөр, түрээсийн орлого 528.3 мянган төгрөгөөр, газрын төлбөр 2,825.7 мянган төгрөгөөр нийт 12 нэр төрлийн орлого 66,301.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь өмнөх онтой харьцуулахад газрын төлбөрийн орлого, малын тоо толгойн албан татвар, бууны албан татварын орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого сүүлийн 2 жил дараалан 13,651.6- 23,107.5 мянган төгрөгөөр тасарсан нь нөлөөлж, татварын орлогын нэр төрлөөр биелүүлэх ажил хангалтгүй, сүүлийн хагас жилд татварын байцаагч ажиллаагүйтэй холбоотой байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 624,906.5 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 407,342.4 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 110,014.1 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 41,695.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 120,000.0 мянган төгрөгөөр хэвээр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 386,607.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 624,906.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 407,342.4 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 110,014.1 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ болон хандивын орлого 41,695.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 120,000.0 мянган төгрөгийг нийт 1,690,565.2 мянган төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,473,240.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 81,422.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, Хоршоо хөгжүүлэх санг 92,162.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,405,033.4 мянган төгрөг буюу 83,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 285,531.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, 33 арга хэмжээнд 654,051.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 480,347.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	81,714.7	75,325.6	6,389.1	92.2
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	597,306.8	550,548.3	46,758.5	92.2
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	158,024.5	157,405.3	619.2	99.6
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	38,988.7	33,655.1	5,333.6	86.3
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	73,331.5	70,031.6	3,299.9	95.5
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	62,147.4	60,070.0	2,077.4	96.7
7	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	120,000.0	70,000.0	50,000.0	58.3
8	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	559,051.6	387,997.5	171,054.1	69.4

9	Дүн	1,690,565.2	1,405,033.4	285,531.8	83.1
---	-----	-------------	-------------	-----------	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 236,379.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 217,690.6 мянган төгрөг зарцуулж, 18,689.1 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу улирал бүр хуралдах	Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу улирал бүр 57,2%-н ирцтэйгээр хуралдсан.	81,714.7	75,325.6
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 8 зорилт, хэрэгжүүлэх 144 арга хэмжээ хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, хэрэгжүүлэх 46 арга хэмжээ 86,1 %-тай дүгнэгдсэн байна.	597,306.8	550,548.3
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	2023 оны 12 дугаар сарын 19-ний 01 тоот Тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн санг 120,000.0 мянган төгрөгөөр баталсан.	Зээлийн эргэн төлөлт муу орж ирсэн эргэн төлөлтөөр 70,000.00 мянган төгрөгийн зээл олгож 3-н төсөл дэмжигдэн ажлаа эхлүүлэн ажиллаж байна.хэрэгжилт 58,3%	120,000.0	70,000.0
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	-Хөгжсөн багшаас чадварлаг сурагч, Хүүхдэд ээлтэй дотуур байр, Хүүхдийн хүмүүжил төлөвшил, “Оюунлаг Төв аймаг” гэсэн 4-н дэд хөтөлбөр	хэрэгжилт 95%	158,024.5	157,405.3
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургалтын орчныг стандартад нийцүүлэн хөгжүүлж, хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээг тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэн, сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэн, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.	Зуны сургалтыг Бүрд, Бараат багт зохион байгуулан, цэцэрлэгт хамрагдаж чадаагүй, хөдөөгийн малчдын 2-5 насны 50 хүүхдийг хамруулан сургасан. Хэрэгжилтийн хувь-100% 2023 онд 74 хүүхэд тогтмол суралцаж байна.	38,988.7	33,655.1
6	71702- Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төв-Соён гэгээрлийн төв 4 төлөвлөгөө 15 арга хэмжээ хэрэгжүүлсэн.	Хэрэгжилт 70%	73,331.5	70,031.6
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Эмнэлгийн тусламж үйлчилгээг жигд хүртээн хэнийг ч орхигдуулахгүйгээр үйлчлэх. Эрт элрүүлгийн урьдчилан сэргийлэх	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг нийт 327 хүн, 4 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 309 хүн хэрэгжилт 68%	62,147.4	60,070.0

			үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх			
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	ОНХС-ийн хөрөнгөөр 15 арга хэмжээ дэвшүүлсэн.	8 арга хэмжээ 100% хэрэгжиж, 5 арга хэмжээ 80%, 2 арга хэмжээ хэрэгжээгүй байна.	559,051.6	387,997.5

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 58,3% тай хэрэгжсэн нь зээлийн эргэн төлөлт муугаас шалтгаалжээ.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 199,312.9 мянган төгрөгөөр 19 нэр төрлийн тоног төхөөрөмж, бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, ерөнхий гэрээгээр 15,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 483,582.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг тендер шалгаруулалтын онцгой журмаар харьцуулалтын аргаар цахим тендер зарлан худалдан авахаар төлөвлөж, бараа ажил үйлчилгээг тендер зарлаж худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын биет бус хөрөнгө данс бүртгэлд тусгах, шилэн данс, татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 01/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийн суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1,690,565.2 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 25,358.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,018.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин, НДШ-ийн зардлыг 29,342.4 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 12,734.4 мянган төгрөг, норматив зардал 126.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 500.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 258.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 3,049.1 мянган төгрөг, бусад зардал 15,815.4 мянган төгрөг, хөрөнгийн зардал 173,704.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 138 мэдээлэл хугацаандаа байршуулж, 21 мэдээлэл хугацаа хоцроож, 19 мэдээлэл байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 419,584.9 мянган төгрөгийн 23 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 538,900.2 мянган төгрөгийн 14 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 287,828.4 мянган төгрөгийн 12 мэдээлэл байршуулж үүнээс 9 мэдээлэл хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 15 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга тайлант онд 25,000 мянган төгрөгөөр нийгмийн хариуцлагын гэрээ Эрдэнэжас ХХК-тай байгуулж, гүйцэтгэлээр 10,000.0 мянган төгрөгөөр сумын төвийн айл өрхүүдийн хашааны өнгө үзэмжийг сэргээн сайжруулах ажил, 5,000.0 мянган төгрөгийг Цомцог гэрийн төлбөрт, 10,000.0 мянган төгрөгөөр ахуй үйлчилгээний худаг гаргах ажил хийсэн байна.

Төв аймгийн Баян-өнжүүл сумын Засаг дарга түүнд харьяалагдах төсвийн шууд захирагч болох Эрүүл мэндийн төв 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайлан гаргаж аудитын байгууллагад ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа татгалзсан дүгнэлт авсан, тайлант онд эрхлэгчийг сольсон ч үр дүнд хүрээгүй, ЭМТ-н үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг явуулж, удирдлага, арга зүйгээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж 2 зөвлөмж өгсөн байна.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилттэй холбоотой 1 төлбөрийн акт, шилэн данстай холбоотой 1 албан шаардлага, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 01/166 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,833.2	1	7,833.2	100
Албан шаардлага	1	1,335,545.5	1	1,335,545.5	100
Зөвлөмж	1	86,123.6	1	86,123.6	100
Нийт дүн	3	1,429,502.3	3	1,429,502.3	100

/мянган төгрөгөөр/

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 6,454,472.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1 албан шаардлага, 6,454,472.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### **5.1 Албан шаардлага**

1. Төв аймгийн Баян-өнжүүл сумын Засаг дарга түүнд харьяалагдах төсвийн шууд захирагч болох Эрүүл мэндийн төв 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайлангийн аудитаар татгалзсан дүгнэлт авсан, тайлант онд эрхлэгчийг өөрчлөн томилсон ч үр дүнд хүрээгүй, дотоод хяналт шалгалтыг явуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20-д “хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, “15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.2 Зөвлөмж**

#### **1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх орлогыг 23,666.9 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх орлогыг 66,301.5 мянган төгрөгөөр нийт 89,968.4 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн 2 шатны орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

### Илрүүлэлт:

2. Газрын мэдээллийн санд бүртгэлтэй сумын Засаг даргын захирамжаар олгогдсон газрыг тулган шалгахад 6,126,504.0 мянган төгрөгийн 6 газар данс бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.5.1-д “Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга, байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд тусгуулах.

## 3. Шилэн данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд шилэн дансны цахим хуудсыг шалгахад тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 238,000.0 мянган төгрөгийн 9 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>4</b>			<b>1</b>		

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс
------------------	------------	--------------------------	--------

			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	81,714.0	1	81,714.0			1	81,714.0		
ЗДТГ	1	597,306.8	1	597,306.8			1	597,306.8		
ОНХС	1	240,875.0	1	240,875.0			1	240,875.0		
Соёлын төв	1	5,950.0	1	5,950.0			1	5,950.0		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>925,845.8</b>	<b>4</b>	<b>925,845.8</b>			<b>4</b>	<b>925,845.8</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	6,216,472.4					2	6,216,472.4
ИТХ	1	2,726.8	1	2,726.8				
ЗДТГ	7	189,857.3	4	112,071.9	2	46,400.0	1	31,403.4
Хоршоо хөгжүүлэх сан	1	128,044.6					1	128,044.6
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>6,537,101.1</b>	<b>5</b>	<b>114,798.7</b>	<b>2</b>	<b>46,400.0</b>	<b>4</b>	<b>6,375,920.4</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	238,000.0					1	238,000.0
ОНХС	1	122,171.9					1	122,171.9
Соёлын төв	1	224,063.4					1	224,063.4
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>584,235.3</b>					<b>3</b>	<b>584,235.3</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засаг дарга	1				1	0		
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>584,235.3</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>584,235.3</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)